


АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



БАТЛАВ
НОМТ МАРАЛ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ж.НАНСАЛМАА



БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 46/2022

2022 оны 04 р сарын 18 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Номт марал ХХК-ийг төлөөлж захирал Ж.Нансалмаа /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “Бичиг хэргийн материал” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 14 /арван дөрөв/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1. Энэ гэрээний нийт үнэ 9,176,000 /есөн сая нэг зуун далан зургаан мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2. Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3. Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан баримт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 14 /арван дөрөв/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5015020559 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Хангамжийн мэргэжилтэн С.Болд хариуцан ажиллана. Утас-99095047.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Номт марал ХХК-ийн захирал Ж.Нансалмаа хариуцан ажиллана. Утас- 99055441.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэж, ноорохоос хамгаалсан сав, баглаа боодолтой, ашиглагдаагүй шинэ байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1. Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлана.
- 8.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1.Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2.Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3.Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4.Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5.Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6.Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7.Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
АЖ АХУЙ, ХАНГАМЖ ЭРХЭЛСЭН
ДЭД ЗАХИРАЛ
Б.УРТНАСАН
Гарын үсэг: 

СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ө.УДВАЛ
Гарын үсэг: 


ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.ГАНТУЛГА
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НОМТ МАРАЛ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ж.НАНСАЛМАА
Гарын үсэг: 



Хаяг: СХД 1-р хороо 28-Б-1 тоот
Утас: 99055441
РД: 6085768

Бичиг хэргийн материалын жагсаалт

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ /НӨАТ/-ай
1	Архивын бор цаас /скоч/	ш	35	7,900	276,500
2	Архивын бор цаас	ш	427	1,500	640,500
3	Бал /госон/	ш	561	1,200	673,200
4	Бал /4 өнгийн/	ш	54	2,500	135,000
5	Баримт үддэг утас /жижиг/	хайрцаг	28	4,500	126,000
6	Балын харандаа	ш	28	600	16,800
7	Зүү	ш	10	850	8,500
8	Хуруувч	ш	36	6,000	216,000
9	Лацны утас	ш	5	6,500	32,500
10	Бичгийн цаас А4 /боодол, 80гр/	ш	281	17,000	4,777,000
11	Маркер	ш	10	3,800	38,000
12	Лац	кг	2	28,000	56,000
13	Фото цаас	боодол	5	29,800	149,000
14	Скоч 12 мм	ш	27	4,900	132,300
15	Скоч 60 мм		58	9,500	551,000
16	Үдээсний машин /хүнд даацын үдэгч/	ш	1	185,000	185,000
17	Цаас зүсэгч АЗ	ш	1	98,000	98,000
18	Нуруулдагч машин	ш	1	230,000	230,000
19	Үдээс авагч	ш	14	4,800	67,200
20	Үдээсний машин	ш	11	12,500	137,500
21	Хайч	ш	23	4,800	110,400
22	Цаас хутга	ш	24	3,800	91,200
23	Цавуу	ш	68	3,100	210,800
24	Штрик	ш	12	4,800	57,600
25	Шугам төмөр /20см/	ш	10	2,000	20,000
26	DVD	ш	50	2,800	140,000
	Нийт үнэ/НӨАТ/-ай	ш			9,176,000

Амгалан дулааны станц ТӨХК-ийн
Хангамжийн мэргэжилтэн
С.Болд
Гарын үсэг: 

Номт марал ХХК-ийн
захирал
Ж.Нансалмаа
Гарын үсэг: 

